



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 10 сарын 19 өдөр

Дугаар А/360

Мөрөн сум

Аймгийн хөдөлмөр, нийгмийн түншлэлийн
гурван талт хороо байгуулах тухай

Аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.6.1 дэх зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Хөдөлмөрийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.4, 15.6, Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт үндэсний хорооны "Салбар хороо болон аймаг, нийслэлийн хорооны дүрэм батлах тухай" 2022 оны 01 дүгээр тогтоолын хоёрдугаар хавсралтын 2.1-ээс 2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Нийгмийн гурван талт түншлэлийн удирдлагыг хэрэгжүүлэх чиг үүрэгтэй аймгийн хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Хорооны дарга: Аймгийн Засаг даргын орлогч

Дэд дарга: Аймгийн Үйлдвэрчний холбооны дарга

Гишүүд:

- Нутгийн захиргааны байгууллагын төлөөлөл:
Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга
Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга
Нийгмийн даатгалын хэлтсийн дарга
Эрүүл мэндийн газрын дарга
Мэргэжлийн хяналтын газрын Хөдөлмөрийн хяналтын улсын байцаагч
- Ажилтны төлөөлөл:
Аймгийн Үйлдвэрчний эвлэлийн холбооны дарга
Нэгдсэн эмнэлгийн үйлдвэрчний эвлэлийн хорооны дарга
Эрдмийн далай цогцолбор сургуулийн үйлдвэрчний эвлэлийн хорооны дарга
Мөрөн нисэх буудлын үйлдвэрчний эвлэлийн хорооны дарга
Мөрөн сумын "Өсөх нахиа" 3 дугаар цэцэрлэгийн үйлдвэрчний эвлэлийн хорооны дарга
Өрхийн эмнэлгүүдийн үйлдвэрчний эвлэлийн хорооны дарга
Хувийн хэвшил, жижиг дунд үйлдвэрийн үйлдвэрчний эвлэлийн хорооны дарга
- Ажил олгогчийн төлөөлөл:
Аймгийн Ажил олгогч эздийн холбооны тэргүүлэгч, "Уудам хангай" ХХК-ны захирал
Аймгийн Ажил олгогч эздийн холбооны тэргүүлэгч, "Зөөлөн" ХХК-ны захирал
Асрамж, хамтын ажиллагаа төрийн бус байгууллагын тэргүүн
"Ундарга тех" ХХК-ны менежер
"Малчин таны төлөө" хоршооны тэргүүн
Ажил олгогч эздийн холбооны ажилтан А.Даваасүрэн

"Идэр зөөлөн" ХХК-ний захирал Н.Отгонбаяр

Нарийн бичгийн дарга:

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга

2. Хөдөлмөрийн тухай хуулинд заасны дагуу орон нутгийн түвшинд хүний хөдөлмөрлөх, түүнтэй холбогдсон эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах бодлогыг хэрэгжүүлж, хэрэгжилтийг хагас бүтэн жилээр тооцон холбогдох байгууллагуудад тайлагнаж ажиллахыг аймгийн хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт хороонд үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (П.Ариунбат)-т даалгасугай.

ДАРГА



Ш.ИДЭРБАЯСГАЛАН